

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 09 ДҮГЭЭР ХУРАЛ**

2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 09 цаг 15 минутад эхэлж, мөн өдрийн 11 цаг 45 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 02 цаг 30 минутад хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Монгол Улсын хууль, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлийн Ховд аймагт холбогдолтой шийдвэрүүдийн хэрэгжилтийн явцын тухай	Монгол Улсын хууль, УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлийн Ховд аймагт холбогдолтой шийдвэрүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын www.new.unelgee.gov.mn цахим сайтад шивж, баталгаажуулан хугацаанд нь хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Б.Баярсүх, тус хэлтсийн мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.
2	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн талаарх танилцуулга	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын www.new.unelgee.gov.mn цахим сайтад шивж, баталгаажуулан хугацаанд нь хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Б.Баярсүх, тус хэлтсийн мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.
3	Ардын хувьсгалын 99 жилийн ойн баяр наадам зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай	Ардын хувьсгалын 99 жилийн ойн баяр наадам зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, өгсөн үүрэг чиглэлийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
4	“Тарваган тахлын голомтот Алтай, Булган, Мөст, Цэцэг, Үенч сумдын иргэдэд сургалт, сурталчилгаа хийх замаар хүний өвчлөл гарах эрсдлийг	“Тарваган тахлын голомтот Алтай, Булган, Мөст, Цэцэг, Үенч сумдын иргэдэд сургалт, сурталчилгаа хийх замаар хүний өвчлөл гарах эрсдлийг бууруулах нь” сургалт сурталчилгаанд

	бууруулах нь” сургалт сурталчилгааны төслийн тухай	Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 сая төгрөгний дэмжлэг үзүүлэх захирамжийн төсөл боловсруулж танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
--	--	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР